

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Макро эдийн засгийн нөхцөл байдал

#### Мөнгөний бодлого

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 12-р сарын сарын 15,16-ны өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж, 13%-д хүргэх шийдвэр гаргасан. Харин 2023 оны 3-р сарын 14, 15-ны өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүний түвшинг хэвээр хадгалж, хүүний коридорыг бодлогын хүүнээс +1,-1 нэгж хувийн өргөнтэй болгон нарийсгасан байна.




#### Дотоодын нийт бүтээгдэхүүн

Бодит ДНБ өсөлт 2022 оны 4-р улиралд хүлээлтээс өндөр буюу 4.8% гарахад БНХАУ-ын "Тэг Ковид" бодлогын арга хэмжээ суларч, эрчим хүч болон худалдааны салбараас бусад салбарын идэвхжил хүлээлтээс өндөр гарсан нь нөлөөллөө. Хилийн хязгаарлалт суларч, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийн төлөв өмнөхөөс сайжрах хүлээлт үүсгээд байна.



Мөн ДНБ 2023 оны 1-р улиралд 7.9% өсөлт үзүүлсэн ба 5.3%-ийг уул уурхай дангаар бүрдүүлж байна. Уул уурхайн энэхүү огцом өсөлт нь БНХАУ хилийн хязгаарлалт суларснаар экспорт нэмэгдсэн, МХБ дээр экспортын нүүрсний арилжаа явагдаж эхэлсэнтэй холбоотой юм.

#### Монгол улсын нүүрсний экспорт




#### Инфляц

Жилийн инфляц 2022 оны 12-р сард 13.2% байсан бол энэ оны 4-р сард 11.3%-тай гарсан байна. 2022 оны 11-р сараас хойш инфляц 5-н сарын турш буурсаар байна.

Монголбанкны инфляцын зорилтот түвшин 6% байгаа ба инфляцын түвшин буурч байгаа нь мөнгөний хатуу бодлогод шилжиж бодлогын хүүг нэмэгдүүлсэн, хятад улсын хилийн гарц бүрэн нээгдэж импортын барааны тээврийн зардал буурсан нь голлон нөлөөлсөн байна.

#### Макро эдийн засгийн цаашдын төсөөлөл

Монгол улсын макро эдийн засгийн цаашдын төсөөллийг Монгол банк, Монголбанкнаас шинжээчдийн дунд явуулсан судалгаа, Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкнуудаас тус тус гаргасан байна.



Дэлхийн банкнаас 2023 оны 4-р сарын 3-нд гаргасан тайланд БНХАУ-ын хилийн хязгаарлалт арилснаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт эрчимтэй өсөх, тэр дундаа Оюу толгойн далд уурхайн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны \*4.8%-аас 5.2% хүрэхээр байна хэмээн тодорхойлсон байна.

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Монгол улсын банк бус санхүүгийн зах зээл

#### Банк бус санхүүгийн үйл ажиллагаа


Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай Монгол улсын хуулинд тусгагдаснаар зээлийн үйлчилгээ,

- факторингийн үйлчилгээ,
- төлбөрийн баталгаа гаргах,
- төлбөр тооцооны хэрэгсэл гаргах,
- цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ,
- богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх,
- үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа

зэргийг явуулах зөвшөөрөл “Санхүүгийн зохицуулах хороо”-ноос авсан аж ахуй нэгжийг хэлнэ.

#### Банк бус санхүүгийн зах зээл

2023 оны 1-р улирлын байдлаар Монгол улсын хэмжээнд 514 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудаас 39 нь финтек зээлийн үйлчилгээ үзүүлдэг байна. Үүнээс 32 нь Финтек болон уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлдэг бол 7 нь зөвхөн финтек зээлийн үйлчилгээ үзүүлдэг байна.




#### ББСБ-уудын хөрөнгийн хэмжээ

ББСБ-уудын 4.9 хувь нь гадаадын, 95.1 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.

ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 3.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 729.2 тэрбум төгрөгөөр буюу 24.5 хувиар, 2019 оны 1 дүгээр улирлаас 165.3 хувиар өсжээ.

Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн:



	ББСБ-ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		багцад эзлэх чанаргүй зээлийн	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ тэрбум	%	Хэмжээ тэрбум	%		Тоо	%
ТОП 27%	5	1.0%	1,012.60	27.4%	793.4	27.7%	1.60%	207,527	5.4%
ТОП 51%	20	3.9%	1,876.50	50.7%	1,522.20	53.1%	3.20%	3,436,825	89.0%
ТОП 75%	101	19.6%	2,775.50	75.0%	2,225.60	77.7%	5.60%	3,756,768	97.3%
Салбарын нийт	514	100.0%	3,702.10	100.0%	2,864.00	100.0%	8.00%	3,862,489	100.0%

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдэл салбарын нийт зээлийн үлдэгдлийн 27.7, 53.1, болон 77.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдлийн эзлэх хувь ойролцоо хэдий ч нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 1.6, 3.2 болон 5.6 хувьтай байна. Өөрөөр хэлбэл салбарт эзлэх хэмжээ их ББСБ-уудын зээлийн чанар салбарын дундажтай харьцуулахад сайн байна. Салбарын нийт хөрөнгийн 50 хувийг бүрдүүлж буй 20 ББСБ-уудын зарим нь үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглан, хүртээмжтэй байдлаар үйлчилгээ үзүүлдэг тул нийт үйлчлүүлэгчдийн 89.0 хувь нь эдгээр ББСБ-уудын харилцагчид болно.

#### ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	3,702.1	100.00%
Эргэлтийн хөрөнгө	3,583.70	96.80%
Мөнгөн хөрөнгө	513.7	13.90%
Зээл /цэвэр/	2,698.60	72.90%
Богино хугацаат хөрөнгө оруулалт/цэвэр/	33.2	0.90%
Факторингийн тооцооны авлага /цэвэр/	9.6	0.30%
Өмчлөх бусад үл хөдлөх бусад хөрөнгө/цэвэр/	22.6	0.60%
Бусад хөрөнгө	306	8.30%
Эргэлтийн бус хөрөнгө	118.3	3.20%

#### ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/


Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	3,702.10	100.00%
Өр төлбөр	1,385.70	37.40%
Санхүүгийн эх үүсвэр	398.6	10.80%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	393.6	10.60%
Бусад эх үүсвэр	48.8	1.30%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	249.6	6.70%
Төслийн зээлийн санхүүжилт	30.2	0.80%
Бусад өр төлбөр	264.9	7.20%
Эздийн өмч	2,316.30	62.60%
Хувьцаат капитал	1,361.10	36.80%
Бусад өмч	61.6	1.70%
Сангууд	1.2	0.00%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	816.4	22.00%
Хоёрдогч өглөг	76	2.10%

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Монгол улсын банк бус санхүүгийн зах зээл

	ББСБ-ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчид	
		Хэмжээ тэрбум	%	Хэмжээ тэрбум	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	489	3,192.3	86.2%	2,446.6	85.4%	3,739,183	96.8%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	20	509.8	13.8%	417.4	14.6%	123,306	3.2%

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын 44.0 хувь буюу 11 нь Япон, 28.0 хувь нь буюу 7 нь БНСУ, 2 нь АНУ-ын үлдсэн нь Их Британи, Канад, Малайз, ОХУ, Сичелл, БНХАУ зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьд салбарын нийт хөрөнгийн 13.8 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 3.2 хувьд үйлчилгээ үзүүлдэг байна.



Салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 35.3 хувиар буюу 710.4 тэрбум төгрөгөөр, 2018 оноос 213.2 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна.

### Зээлийн жигнэсэн дундаж хүү

**2.7%** >>> **3.1%**  
2021.IV                      2022.I - 2023.I

ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.1 хувь байгаа нь 2022 оны 1-р улирлаас хойш тогтмол байна.

### Хэвийн зээл

**87.6%** -0.9% 2022.I

### Хугацаа хэтэрсэн зээл

**4.4%** +0.5% 2022.I

### Чанаргүй зээл

**8.0%** +0.4% 2022.I

Төлөгдсөн зээл  
1.3 их наяд төгрөг

Олгосон зээл  
1.4 их наяд төгрөг

Бөөний болон жижэглэн худалдаа



9.4% 9.7%

Барилга



3.0% 3.3%

Уул, уурхайн олборлолт



0.7% 0.8%

Машин, мотоциклын засвар үйлчилгээ



1.9% 2.1%

Байр сууц, хоол хүнсний үйлчилгээ



1.6% 1.3%

Боловсруулах үйлдвэр



0.7% 0.7%

Хөдөө аж ахуй



0.4% 0.5%

Бусад



82.3% 81.6%

Улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр 514 ББСБ болон түүний 428 салбар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 81.7 хувь нь Улаанбаатар хотод байна. 420 ББСБ-ын

- 33.1 хувь нь Сүхбаатар дүүрэгт,
- 27.4 хувь нь Чингэлтэй дүүрэгт,
- 16.9 хувь нь Баянгол дүүрэгт,
- 11.0 хувь нь Баянзүрх дүүрэгт,
- 9.3 хувь нь Хан-Уул дүүрэгт,
- 2.1 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт,
- 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршилтай байна.

### Нэг зээлдэгчид ногдох зээлийн дүн

Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 2.2 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 2.7 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 2.2 сая төгрөг байна.

**2,200,000**

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Монгол улсын банк бус санхүүгийн зах зээл

#### Ногоон зээл



Нийт зээлийн үлдэгдлийн 4.0 хувь буюу 114.8 тэрбум төгрөг байгаа нь бтөрлийн зээлийг 8413 зээлдэгчид олгосон дүн юм.

	Ногоон зээлийн хувь	Зээлдэгчийн тоо	Зээлийн үлдэгдэл (сая.төгрөг)
Карбон бага ялгаруулагч тээвэр	91.6%	7,532	105,162.9
Ногоон барилга	7.4%	800	8,445.5
Тогтвортой хөдөө аж ахуй газар ашиглалт, ой	0.7%	17	837.7
Эрчим хүчний хэмнэлт	0.3%	61	370.9
Бага бохирдуулагч эрчим хүч	0.0%	2	0.1
Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа	0.0%	1	0.1

#### Финтек

З ө в х ө н технологийг суурилсан **7** Технологи + Уламжлалт **32**



Салбарын нийт харилцагчдын 94.2 хувь нь эдгээр ББСБ-ын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртсэн.

Нийт зээлдэгчдийн 76.0 хувь нь финтек зээлдэгч буюу технологи ашиглаж зээл авсан бөгөөд тус зээл нь нийт зээлийн дүнгийн 19.3 хувийг эзэлж байна.

#### Хэвийн зээл (Финтек)

**88.2%**

#### Хугацаа хэтэрсэн зээл

**4.6%**

#### Чанаргүй зээл

**7.2%**

Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 88.2 хувийг хэвийн 4.6 хувийг хугацаа хэтэрсэн 7.2 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлээ.

#### Ашигт ажиллагаа

##### Нийт орлого

**258.5**  
тэрбум төгрөг

##### Нийт зарлага

**159.0**  
тэрбум төгрөг

#### Цэвэр ашиг

**99.6** тэрбум төгрөг

#### Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)

**4.8%** +0.0% 2022.1

#### Нийт хөрөнгийн өгөөж (ROA)

**3.0%** +0.1% 2022.1

#### Зээлийн эрсдэлийн сан

##### Байгуулбал зохих эрсдэлийн сан



##### Байгуулсан эрсдэлийн сан



Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа 105.8 хувь гарч байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг мөн хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Олон нийтэд нээлттэй банк бус санхүүгийн байгууллагууд

#### МХБ дээр бүртгэлтэй ББСБ-ууд

Ард кредит ББСБ ХК   ADB	1-р ангилал
Инвескор ББСБ ХК   INV	
ЛэндМН ББСБ ХК   LEND	
Сэндли ББСБ ХК   SEND	2-р ангилал
Тандэм инвест ББСБ ХК   VIK	

#### Хувьцаат компани 1-р ангилал

10 тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай. Нийт хувьцааны 25 - аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх, эсхүл тухайн компанийн хувьцааны хагас жилээрх арилжигдсан үнийн дүн нь биржээр арилжаалагдсан хувьцааны нийт арилжааны үнийн дүнгийн 5 - аас доошгүй хувь байх шалгуур, шаардлагыг тус тус хангасан байна.

#### Хувьцаат компани 2-р ангилал

1 тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай, нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх шалгуур, шаардлагыг тус тус хангасан байна.

#### Топ-20 индекс ба ББСБ

Топ 20 индекс нь Монголын Хөрөнгийн Биржээс гаргадаг индекс бөгөөд 20 компаниас багцаа бүрдүүлдэг. Жилд 2 удаа багцдаа өөрчлөлт оруулдаг байна. Шалгуур үзүүлэлт нь зах зээлд идэвхтэй арилжаалагдсан байдал, зах зээлийн үнэлгээ өндөр байх явдал юм.

Топ-20 индекст нийтдээ 3-н ББСБ багтсан бөгөөд 5-рт Инвескор ББСБ ХК, 16-рт Ард кредит ББСБ ХК, 19-рт Сэндли ББСБ ХК багтсан байна.

Топ-20 индекс




Эх сурвалж: МХБирж, [www.mse.mn](http://www.mse.mn)


#### Арилжааны идэвх

Нээлттэй 5-н ББСБ-уудын сүүлийн 3-н жилийн арилжааны нийт дүнгээр харьцуулахад нийт арилжааны дүнгээр INV, ADB хамгийн өндөр дүнгээр арилжаалагдсан байна. Харин хамгийн олон тоогоор ABD, LEND арилжаалагджээ.

Арилжааны дүн



Арилжаалагдсан ширхэг



Эх сурвалж: МХБирж, [www.mse.mn](http://www.mse.mn)

#### Ханшийн хамаарал

ТОП-20 индекс ба ADB, INV, LEND, SEND, VIK ББСБ-уудын сүүлийн 3-н жилийн ханшийн хөдөлгөөний хамаарлыг судлахад INV, ADB, SEND нь ТОП-20 дотор багтдаг тул ТОП-20 индекстэй хамгийн өндөр хамааралтай байна. Харин LEND, VIK нь хамгийн хамаарал багатай байна.

	TOP-20	ADB	INV	LEND	SEND	VIK
TOP-20	1.00	0.61	0.74	0.06	0.31	0.29
ADB	0.61	1.00	0.10	0.33	0.26	0.25
INV	0.74	0.10	1.00	-0.41	-0.49	0.11
LEND	0.06	0.33	-0.41	1.00	0.44	0.24
SEND	0.31	0.26	-0.49	0.44	1.00	0.35
VIK	0.29	0.25	0.11	0.24	0.35	1.00

Эх сурвалж: МХБирж, [www.mse.mn](http://www.mse.mn)

Хувьцааны үнийн хамаарал нь -1 -ээс +1-ийн хооронд байх ба хамаарал нь зэрэг утгатай байвал нэг нь өсөхөд нөгөө нь дагаж өсөх хандлагатай байдаг бол сөрөг утгатай байвал нэг нь өсөхөд нөгөө нь буурах хандлагатай байна. 0 утгатай байвал хамааралгүй болохыг илэрхийлнэ.

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Олон нийтэд нээлттэй банк бус санхүүгийн байгууллагууд

#### Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Нээлттэй ББСБ-уудын 2022 оны санхүүгийн байдлын тайлан, орлогын тайлангийн үзүүлэлтүүдийг авч үзэхэд дараах байдалтай байна.

	Нийт хөрөнгө	Өр төлбөр	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг	ROE	ROA
ADB	58,053.5	39,957.4	18,096.1	11,339.3	2,105.9	11.6%	3.6%
INV	358,510.9	235,257.6	123,253.3	81,051.6	33,505.8	27.2%	9.3%
LEND	76,858.8	52,628.9	24,229.9	20,215.0	5,525.0	22.8%	7.2%
SEND	34,891.3	13,465.5	21,425.8	3,825.1	3,064.3	14.3%	8.8%
VIK	18,022.0	3,765.6	14,256.4	3,051.9	1,993.6	14.0%	11.1%

Эх сурвалж: МХБирж, [www.mse.mn](http://www.mse.mn)

Дээрх хүснэгтээс үзвэл хамгийн өндөр өөрийн хөрөнгийн өгөөжтэй компани “Инвекор ББСБ ХК” ба “ЛэндМН ББСБ ХК” байна.

Хамгийн өндөр нийт хөрөнгийн өгөөжтэй компани “Тандэм инвест ББСБ ХК” ба “Инвекор ББСБ ХК” байна.

Хамгийн өндөр цэвэр ашгийн маржинтай компани “Сэндли ББСБ ХК” байна.

	P/E	P/B	Нийт хувьцаа	Зах зээлийн үнэлгээ
ADB	17.1	2.0	280,000,000	36,041.6
INV	11.3	3.1	75,744,281	379,100.1
LEND	4.5	1.0	800,000,000	24,712.0
SEND	12.1	1.7	223,570,000	37,110.4
VIK	16.3	2.3	1,508,116,708	32,424.5

Эх сурвалж: МХБирж, [www.mse.mn](http://www.mse.mn)

#### Сэндли ББСБ ХК

CAGR | сүүлийн 3 жил

P/E	Нийт хөрөнгө	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг
12.1	330%	271%	193%	299%

#### Тандэм инвест ББСБ ХК

P/E	Нийт хөрөнгө	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг
16.3	170%	140%	118%	206%

#### Инвекор ББСБ ХК

P/E	Нийт хөрөнгө	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг
11.3	62%	53%	67%	71%

#### ЛэндМН ББСБ ХК

P/E	Нийт хөрөнгө	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг
4.5	37%	17%	11%	51%

#### Ард кредит ББСБ ХК

P/E	Нийт хөрөнгө	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг
17.1	40%	27%	34%	2%

P/E харьцааны хувьд “Тандэм инвест ББСБ ХК”, “Инвекор ББСБ ХК” нь тус тус 16.3, 11.3 байна.

Дээрх үзүүлэлтүүдийг харьцуулж үзэхэд “Сэндли ББСБ ХК” ба “Тандэм инвест ББСБ ХК” сүүлийн 3-н жилийн хугацаанд хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байна.

“ЛэндМН ББСБ ХК”-ийн хувьд P/E харьцаа хамгийн бага буюу 4.5 байгаа нь LEND багаар үнэлэгдсэн байгааг харуулж байна.

#### Онцлох хувьцаа

“Сэндли ББСБ ХК” нь 2015 онд үүсгэн байгуулагдсан ББСБ ба дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм. Үүнд Зээлийн үйлчилгээ,

Гадаад валютын арилжаа, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, Факторинг, Итгэлцэл, Төлбөрийн баталгаа гаргах

“Сэндли ББСБ ХК” нь 2022 оны 9-р сард олон нийтэд 29.97% буюу 67 сая хувьцааг 150₮ нэгж хувьцааны үнэтэйгээр нийт 10.05 тэрбум төгрөгийн санал болгосон билээ.

**150₮** 2022.09 **»»»** **165₮** 2023.7.24

Эх сурвалж: МХБирж, [www.mse.mn](http://www.mse.mn)

#### Сэндли ББСБ ХК

P/E	Нийт хөрөнгө	Эздийн өмч	Хүүгийн орлого	Цэвэр ашиг
12.1	330%	271%	193%	299%

“Сэндли ББСБ ХК” нь сүүлийн 3-н жилийн жигнэсэн дундаж өсөлтөөс (CAGR) харахад цэвэр ашиг 299%, хүүгийн орлого 193%, нийт хөрөнгө 330%, эздийн өмч 271% өссөн байна.

Мөн SEND хувьцааны P/E харьцаа бодит үнэлэгдсэн байгаа нь энэхүү хувьцааны үнэ цэн цаашид илүү өсөх хандлагатай байгааг харуулж байна.

## Зах зээлийн судалгаа | Банк бус санхүүгийн байгууллага

### Судалгааны дүгнэлт

#### ББСБ-уудын харилцагчид, зээлдэгчид

2022 оны 3-р улиралд нийт зээлдэгчдийн тоо өмнөх улирлаас өссөн хэдий ч уламжлалт зээлдэгчдийн тоо 48.7%-иар буурсан билээ.

2022 оны дунд үед ББСБ-ууд зээл олгох санхүүжилтийн нийлүүлэлт багассантай холбоотойгоор санхүүжилт татах зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор ББСБ-уудын зээл олгох тоо багассан ба зээлийн шалгуур нэмэгдсэн билээ. Үүнээс үүдэн шинээр нэмэгдэх зээлдэгчдийн тоо огцом буурчээ.

Банк бус санхүүгийн салбар нь цаг тутам зээлдэгчид зээлээ хааж байдаг учир зээлийн багц цаашлаад хүүгийн орлого, цэвэр ашгаа бууруулахгүйн тулд үргэлж зээл хүсэгчдийг эрэлхийлж байдгаараа онцлог билээ.

#### Финтек

Финтек зээлдэгчдийн дийлэнх хувь нь барьцаагүй хэрэглээний зээлдэгчид бөгөөд энэхүү зээл НДШ дээр суурилж зээл авах боломжтой дүн тооцоологддог зээлийн бүтээгдэхүүн юм. Мөн энэхүү зээлийн бүтээгдэхүүн маань зээлдэгчдэд заавал барьцаа хөрөнгөтэй байх шаардлагагүйгээр зээл авах боломжийг олгож байсан нь зах зээлд нэвтэрсэн цагаасаа зээл хүсэгчдийг шуурцуулж байсан бол 2022 оны 3-р улиралд ББСБ-ууд кредит скоринг буюу зээл гаргах боломжтой дүнг тооцох шалгуураа нэмэгдүүлсэн нь зээлдэгчдийн тоог буурахад хүргэж зээл хүсэгчдийн шуургыг намдаасан билээ.

Хэдийгээр зээлийн шалгуур нэмэгдсэн ч финтек зээлийн багц нь улирал бүр нэмэгдсээр байгаа нь финтекийн зах зээл өдөр ирэх тусам улам томорсоор байгааг илтгэж байна. Цаашид ч ийм хандлагатай байх төлөвтэй байна.

#### Зээлийн багц

Зээлийн багц нь ББСБ-уудын хувьд голлох чухал үзүүлэлт билээ. Зээлийн багц их байх тусам түүнээс орж ирэх хүүгийн орлого дагаад ихэсдэг. Мөн зээлдэгчид зээлээ төлөх бүр зээлийн багц буурдаг тул ББСБ-уудын хувьд зээл гаргах замаар зээлийн багцаа нэмэгдүүлэх нь гол зорилго нь юм. Сүүлийн 1 жилийн улирал тутмын дундаж өсөлт 142.6 тэрбум төгрөг байхад зээл олголт багассантай холбоотойгоор 2022 оны 3-р улиралд 56.5 тэрбум төгрөгийн зээлийн багцын өсөлт үзүүлсэн байсан бол 2022 оны 4-р улирлаас хэвийн болжээ.

#### Чанаргүй зээл

Зээлийн төлөлт хийгдэхгүй 90+ хоног болсон тохиолдолд тухайн зээл чанаргүй зээлийн төрөлд ордог ба чанаргүй зээлдэгч болсон тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэгддэг. Ингэснээр тухайн зээлдэгч дахин зээл авах боломжгүй болдог байна.

Чанаргүй зээлийн хувь гэдэг нь зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн үлдэгдлийн дүнг хэлдэг бөгөөд 2023 оны 1-р улиралд ББСБ салбарын үзүүлэлт маань 8.0%-тай байсан бол финтек чанаргүй зээлийн хувь 7.2% байсан байна.

ББСБ-ууд чанаргүй зээлийн хувийг хамгийн бага байлгах дээр илүү төвлөрдөг ба ихэнх ББСБ-ууд чанаргүй зээлтэй ажиллах тусгай баг хүртэл ажиллуулдаг.

#### Ашигт ажиллагаа

2023 оы 1-р улиралд ББСБ-ын салбарын нийт орлого 258.5 тэрбум төгрөг, цэвэр ашиг 99.6 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 4.8%, нийт хөрөнгийн өгөөж 3.0% байсан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулвал нийт орлого 40.2%, цэвэр ашиг 26.7% өссөн бол нийт хөрөнгийн өгөөж 0.1%-р өсжээ.

Мөн 2022 оны санхүүжилтийн хомсдолтой холбоотойгоор зээл олголт буурсан ба багцын өсөлт багассан тул цэвэр ашгийг бууруулахгүйн тулд ББСБ-ууд зээлийн хүүг нэмэгдүүлсэн билээ.

#### Сургамж

ББСБ-ууд тогтмол зээл олгох нь тогтвортой оршин тогтнох гол үндэс бөгөөд ББСБ-ууд зээл олгох санхүүжилтийн эрэлтээ хангах нь мөн үүнтэй салшгүй холбоотой чухал зүйл билээ. ББСБ салбарт санхүүжилтийн нийлүүлэлтийн хомсдолоос зайлсхийх гарцууд нь ББСБ-ууд нээлттэй компани болох, харилцагчдаас итгэлцэл татах, хөрөнгийн зах зээлд оролцох боломжууд байна.

#### Судалгаа бэлтгэсэн:

Шинжээч: Б. Ганхуяг  
Ulzii & Co Capital LLC  
Tel: 976-8058-6377  
E-mail: [ganaa@ucc.mn](mailto:ganaa@ucc.mn)

#### Ашигласан материал:

СЗХороо, Санхүүгийн салбарын тойм 2023 оны 1-р улирал,  
<http://www.frc.mn/resources/Images/Document/202305/Toim-2023q1-last-2023.05.17.pdf>